

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/319/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН БАТСҮМБЭР СУМЫН БАЯНГОЛ ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал
Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn
Аудитын менежер: О.Амаржаргал
Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Голден пэйж Аудит" ХХК
захирал: С.Оюунгэрэл

Утас: 70117179 Цахим хаяг: info@goldenpageaudit.mn

АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
 - 4.1 Ерөнхий зүйл
 - 4.2 Материаллаг байдал
 - 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
 - 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
 - 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
 - 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 01/82

танай _____-ны № _____-г

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд Батсүмбэр сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 47,582.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 224,515.3 мянган төгрөгийн үнэтэй үнэдсэн хөрөнгө, 4,729.5 мянган төгрөгийн үнэтэй бараа материалыг балансаас балансад шилжүүлэн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Төв аймгийн Батсүмбэр сумын хүүхдийн цэцэрлэг "Сургуулийн өмнөх боловсролыг хүүхдийн төлөвшил, хөгжлийн суурь үе хэмээн үзэж, цэцэрлэгийн

019020087

үйлчилгээний болон сургалтын чанарыг сайжруулахад чиглэсэн цогц үйл ажиллагааг зохион байгуулна” гэсэн зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Цэцэрлэгийн эрхлэгч нь Төв аймгийн боловсрол шинжлэх ухааны газрын даргаар батлуулсан гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 12 зорилтын хүрээнд 34 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, 90 хувийн гүйцэтгэлтэй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	=	<u>55,577,312.73</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	54,127,447.73
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	-	54,127,447.73
3121	Төгрөг	-	54,127,447.73
31211	Төрийн сангийн харилцах	-	54,127,447.73
35	БАРАА МАТЕРИАЛ	-	1,449,865.00
354	Хангамжийн материал	-	1,449,865.00
35460	Хүнсний материал	-	1,449,865.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	=	<u>180,923,217.33</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	-	180,923,217.33
392	Биет хөрөнгө	-	180,923,217.33
39201	Барилга, байгууламж, орон сууц	-	179,279,220.05
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	(8,634,643.68)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	-	29,167,880.63
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	(21,827,302.39)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	-	14,550,734.23
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	(12,502,349.40)
39214	Бусад үндсэн хөрөнгө	-	1,841,504.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	(951,826.11)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	=	<u>236,500,530.06</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	=	<u>236,500,530.06</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	-	236,500,530.06
512	Хуримтлагдсан үр дүн	-	236,500,530.06
51220	Тайлант үеийн үр дүн	-	236,500,530.06
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	=	<u>236,500,530.06</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	-	621,128,387.44
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	-	183,106,287.44
120	Нийтлэг татварын бус орлого	-	183,106,287.44
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	-	183,106,287.44
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	183,106,287.44
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	20,785,600.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	417,236,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	20,785,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	20,785,600.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	-	384,627,857.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	384,627,857.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	383,520,678.72
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	276,500,587.13
210101	Үндсэн цалин	-	200,910,617.69
210102	Нэмэгдэл	-	65,743,025.28
210104	Урамшуулал	-	9,846,944.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	33,939,432.39
210201	Тэтгэврийн даатгал	-	23,314,542.03
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,742,899.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,194,439.25
210204	Ажилгүйдлийн даатгал	-	534,635.92
210205	Эрүүл мэндийн даатгал	-	5,152,916.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	19,162,421.34
210301	Гэрэл, цахилгаан	-	6,868,921.34
210302	Түлш, халаалт	-	11,593,500.00
210303	Цэвэр, бохир ус	-	700,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	1,172,400.00
210402	Тээвэр, шатахуун	-	1,172,400.00
2105	Нормативт зардал	-	44,257,267.75
210502	Хоол, хүнс	-	42,848,867.75
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,408,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	216,000.00
210604	Урсгал засвар	-	216,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	686,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	686,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,586,270.11
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,200,700.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	202,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	-	183,570.11
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,107,178.66
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,107,178.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,107,178.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-	236,500,530.06
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	=	236,500,530.06

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	-	438,022,100.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	438,022,100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	-	417,236,500.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	-	20,785,600.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	-	20,785,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	-	381,494,652.27
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	381,494,652.27
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	380,387,473.61
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	276,237,683.13
210101	Үндсэн цалин	-	193,246,284.03
210102	Нэмэгдэл	-	73,144,454.94
210104	Урамшуулал	-	9,846,944.16
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	34,202,336.39
210201	Тэтгэврийн даатгал	-	23,314,542.03
210202	Тэтгэмжийн даатгал	-	2,742,899.08
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	2,194,439.25
210204	Ажилгүйдлийн даатгал	-	534,635.92
210205	Эрүүл мэндийн даатгал	-	5,415,820.11
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	19,162,421.34
210301	Гэрэл, цахилгаан	-	6,868,921.34
210302	Түлш, халаалт	-	11,593,500.00
210303	Цэвэр, бохир ус	-	700,000.00
2105	Нормативт зардал	-	39,899,232.75
210502	Хоол, хүнс	-	39,899,232.75
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	516,000.00
210604	Урсгал засвар	-	516,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	686,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	686,300.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	9,683,500.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	7,379,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,303,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	1,107,178.66
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	-	1,107,178.66
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	1,107,178.66
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=	56,527,447.73
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	2,400,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	2,400,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	2,400,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	2,400,000.00

6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=	<u>(2,400,000.00)</u>
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	54,127,447.73
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	54,127,447.73

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
D01	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	236,500,530.06	236,500,530.06
D09	2023 оны.12-р сарын 31-нээрх үлдэгдэл	236,500,530.06	236,500,530.06

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	417,236,500.00	363,109,052.27	54,127,447.73	87,0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,236,500.00	363,109,052.27	54,127,447.73	87,0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	417,236,500.00	363,109,052.27	54,127,447.73	87,0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	317,319,400.00	276,237,683.13	41,081,716.87	87,1
210101	Үндсэн цалин	204,292,000.00	193,246,284.03	11,045,715.97	94,6
210102	Нэмэгдэл	103,088,500.00	73,144,454.94	29,944,045.06	71,0
210104	Урамшуулал	9,938,900.00	9,846,944.16	91,955.84	99,1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	39,498,300.00	34,202,336.39	5,295,963.61	86,6
210201	Тэтгэврийн даатгал	27,015,600.00	23,314,542.03	3,701,057.97	86,3
210202	Тэтгэмжийн даатгал	3,120,300.00	2,742,899.08	377,400.92	87,9
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,497,300.00	2,194,439.25	302,860.75	87,9
210204	Ажилгүйдлийн даатгал	624,000.00	534,635.92	89,364.08	85,7
210205	Эрүүл мэндийн даатгал	6,241,100.00	5,415,820.11	825,279.89	86,8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,035,600.00	19,162,421.34	873,178.66	95,6
210301	Гэрэл, цахилгаан	7,742,100.00	6,868,921.34	873,178.66	88,7
210302	Түлш, халаалт	11,593,500.00	11,593,500.00	0.00	100,0
210303	Цэвэр, бохир ус	700,000.00	700,000.00	0.00	100,0
2105	Нормативт зардал	47,432,900.00	39,899,232.75	7,533,667.25	84,1
210502	Хоол, хүнс	47,432,900.00	39,899,232.75	7,533,667.25	84,1
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	750,000.00	516,000.00	234,000.00	68,8
210604	Урсгал засвар	750,000.00	516,000.00	234,000.00	68,8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	769,500.00	686,300.00	83,200.00	89,2
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	769,500.00	686,300.00	83,200.00	89,2
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,216,400.00	12,083,500.00	132,900.00	98,9
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,907,800.00	9,779,600.00	128,200.00	98,7
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,308,600.00	2,303,900.00	4,700.00	99,8
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	438,022,100.00	438,022,100.00	-	100,0
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	417,236,500.00	417,236,500.00	-	100,0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	417,236,500.00	417,236,500.00	-	100,0
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	20,785,600.00	20,785,600.00	-	100,0
132001	Орон нутгийн төсвөөс	20,785,600.00	20,785,600.00	-	100,0
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	54,127,447.73		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	21	21	-	100,0
620001	Удирдах ажилтан	1	1	-	100,0
620002	Гүйцэтгэх ажилтан	10	10	-	100,0
620003	Үйлчлэх ажилтан	10	10	-	100,0

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэг нь хоёр наснаас сургуульд элсэх хүртэлх насны хүүхдийг асрах, хамгаалах, хүмүүжүүлэх, сургах цогц үйл ажиллагаагаар хүүхдийн бие бялдар, оюун ухаан, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих сургалтыг эзэмшүүлэх чиг үүрэгтэй үйл ажиллагаа явуулдаг Боловсрол, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага юм.

Тайлант онд эрхлэгч 1, багш 10, тогооч 4, галч 4, нийт 19 орон тоотойгоор ажиллаж, нийт 125 хүүхэдтэй үйл ажиллагаа явуулж эцэг эхтэй шууд болон шууд бусаар хамтран ажилласан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Цэцэрлэг нь сургалт, үйл ажиллагааны орчинд суралцагчийн аюулгүй байдлыг хангах, хамгаалах, мэдлэг чадвар авьяасаа хөгжүүлэх, төлөвшихөд дэмжлэг үзүүлэх, хүүхдийн хөгжил, төлөвшил, сурах үйл явцын талаар эцэг эх асран хамгаалагч, дэмжигчтэй хамтран ажиллах чиг үүргийг гүйцэтгэнэ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд доорх өөрчлөлт орсон. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Боловсролын ерөнхий хууль
- Сургуулийн өмнөх болон боловсролын тухай хууль
- Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль
- Зөвшөөрлийн тухай хууль
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 240 дүгээр тогтоолоор төрийн үйлчилгээний албан тушаалын зэрэглэл, албан тушаалын жагсаалт
- Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор Төрийн цалингийн доод хэмжээг тогтоосон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудит аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь үйл ажиллагааны онцлог, холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 236,500.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	54,127.4	54,127.4
Бараа материал	0.0	1,449.9	1,449.9
Үндсэн хөрөнгө	0.0	180,923.2	180,923.2
Нийт хөрөнгө	0.0	236,500.5	236,500.5
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	0.0	0.0	-
Хуримтлагдсан үр дүн	0.0	236,500.5	236,500.5
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	0.0	236,500.5	236,500.5

Дээрх хүснэгтээс харахад нөлөө бүхий өөрчлөлт мөнгөн хөрөнгө, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Мөнгөн хөрөнгийн данс 54,127.4 мянган төгрөгөөр өссөн нь орж ирсэн санхүүжилтийн цалингийн зардал хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материал 1,449.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант онд 48,653.9 мянган төгрөгийн худалдан авалт, 4,399.5 мянган төгрөгийн бараа материал балансаас балансад шилжиж ирж орлогдсон, 51,603.6 мянган төгрөгийн бараа материал шаардахын дагуу зарлагадаж 1,449.9 мянган төгрөгийн хүнсний материал үлдсэн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл 180,923.2 мянган төгрөг болсон нь Батсүмбэр сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 12 дугаар сарын 21-ны өдрийн 10 дугаар тогтоолоор 47,582.6 мянган төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй 224,515.3 мянган төгрөгийн үнэтэй үнэдсэн хөрөнгө балансаас балансад шилжин ирсэн байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 417,236.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 20,785.6 мянган төгрөг, зарлагыг 438,022.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлж батлуулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 417,236.5 мянган төгрөгийн санхүүжилт, орон нутгийн төсвөөс 20,785.6 мянган төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 382,787.5 мянган төгрөг буюу 87,4 хувьтай зарцуулсан байгаа нь цалин хөлсний зардлыг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

Д/ Д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгө ө	/мянган төгрөгөөр/		
			Гүйцэтгэл	Зөрүү	Биелэл т
1	81605 Эрүүл мэндийг дэмжих	1,154.30	1,040.00	114.30	90,1
2	81807 Цэцэрлэгийн хүүхдийн хоол	47,432.90	39,899.23	7,533.67	84,1
3	81816 Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	255,323.80	255,323.80	-	100,0
4	81823 Боловсролын байгууллагын багш, ажилтны мэргэжил дээшлүүлэх	109,766.40	109,766.40	-	100,0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Худалдан авах ажиллагааг хичээл үйлдвэрлэл 2,308.6 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний зардлыг 5,194.4 мянган төгрөгөөр, хоол хүнс 47,432.9 мянган төгрөгөөр нийт 54,935.9 мянган төгрөгөөр батлуулж гүйцэтгэлээр хичээл үйлдвэрлэл 2,303.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний зардал 5,185.6 мянган төгрөг, хоол хүнс 39,899.2 мянган төгрөг нийт 47,388.7 мянган төгрөг зарцуулсан 86.3 хувийн гүйцэтгэлтэй худалдан авалтыг хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Голден пэйж Аудит ХХК-ийн аудитор Б.Дашням, Шинжээч Б.Ариунтуяа, Ц.Цацрал нар гүйцэтгэж, анхан шатны хяналтыг аудитын менежер, гүйцэтгэх захирал С.Оюунгэрэл хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Саранчимэг, аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Батсүмбэр сумын Баянгол цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Голден пэйж Аудит ХХК-д 2024 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны хагас жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 254,647.1 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 3,819.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,864.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны жилийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 621,128.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 4,327.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь бүтэц орон тоог нэмэгдүүлэхгүй байх, үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг төвийн захирал албан томилолтоор ажилласан зардлаа авахгүй байх зэргээр зардлыг хэмнэх арга хэмжээг авч ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

1. Тайлант хугацаанд шилэн дансанд нийт 159 мэдээ мэдээллээс 145 мэдээллийг хугацаанд нь байршуулж, хугацаа хоцорсон 6 мэдээлэл, 8 мэдээлэл байршуулаагүй, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш өссөн дүнтэй 55,072.9 мянган төгрөгийн гүйлгээг оруулаагүй байгаа нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6 дугаар зүйлийн 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.4-д "таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр" заалттай нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансанд мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлдэг байх зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай /бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

1. Засгийн газрын хувь оролцоо санхүүгийн тайлангаар 0 төгрөг, байгууллагын гэрчилгээгээр 224,688.4 төгрөг байгаа нь санхүүгийн тайланд тусгагдсан ажил гүйлгээ буюу үйл явдал, үлдэгдэл нь тооцооллын алдаагүй, зөв хураангуйлж бүртгэсэн байх гэсэн батламж мэдэгдэлтэй нийцээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Үнэн зөв баталгаажуулах, бүртгэлдээ өөрчлөлтийг оруулдаг байх зөвлөмж хүргүүлэв.

2. Тайлант хугацаанд 2023 оны ААНОАТ-ын тайланг илгээгээгүй хоцорсон төлөвтэй байна. Хуульд заасан хугацаанд татварын тайлан ирүүлээгүй тохиолдолд Зөрчлийн тухай хуулийн 11.19 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага тооцох эрсдэлтэй байна.

Шийдвэрлэсэн нь: Тайланг хуулийн хугацаанд тайлагнадаг байх, байгууллага ААНОАТ тайлан тушаадаггүй бол төрлийг хасуулах зөвлөмж хүргүүлэв.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар анхан шатны и-баримтын бүрдэл, Засгийн газар оролцоо сангийн бүртгэл, цалинтай холбоотой бүртгэл, шилэн дансны мэдээлэл, бичиг хэрэг хөтлөлт,

өглөгийн данстай холбоотой нийт 4 зөвлөмж хүргүүлснээс 1 зөвлөмж хэрэгжүүлэн ажилласан, 3 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайланд аудит хийгдээгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитын явцад дараагийн аудитаар анхаарах асуудал төсөв, санхүүжилтийг үндэслэлтэй баталдаг байх, төрийн чиг үүргийг хангалттай хэрэгжүүлэн ажиллах талаар анхаарал хандуулах болно. Баянгол цэцэрлэгийн байр халаалт муу, хүүхдүүдийн хоол бэлтгэх гал тогоо стандарт бус эрүүл ахуйн шаардлага алдагдсан байдалтай, ажилчдын ажиллах нөхцөл хүнд байдалтай байна энэ талаар дараагийн аудитаар авч үзнэ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 1,860.5 мянган төгрөгийн 1 зөрчил илэрснээс, 1,860.5 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, дахин давтахгүй байх 1 зөвлөмж хүргүүллээ.

5.1 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

Мөнгөн хөрөнгийн түүврээр Цахим баримтын бүрдэлд 1,860.5 мянган төгрөгийн зөрүүтэй гүйлгээ гарсан байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно", Сангийн сайдын 2017 оны 347 тоот тушаалаар батлагдсан "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар"-ын 6.5-д Төлбөрийн баримт "Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм. Төлбөрийн баримтад борлуулагч, худалдан авагчийг таних тэмдэг, татвар төлөгчийн дугаар, төлбөр тооцоо хийгдсэн он, сар, өдөр, бараа, ажил, үйлчилгээний нэр, код, тоо хэмжээ, үнэ, татварын дүнг тусгана. Төлбөрийн баримтыг цахим гарын үсэг эсхүл тусгай нууцлалын QR кодоор баталгаажуулах бөгөөд Монгол Улсын Стандарт MNS 6529:2015 "Татварын нэгдсэн системд ашиглах төлбөрийн баримтын ерөнхий шаардлага"-д заасан загварын дагуу бүртгэлийн машинаар хоёр хувь үйлдэнэ." Гэсэн заалтуудтай зөрчилдөж байна

Өгсөн зөвлөмж: Цахим баримтын бүрдэлгүй гүйлгээ гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цахим баримтын зөрүүтэй гүйлгээ хийсэн	1	1,860.5					1	1,860.5				
Дүн	1	1,860.5					1	1,860.5				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс						
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил									
Шилэн дансанд 6 мэдээлэл хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мөнгөн гүйлгээг 55,072.9 мянган төгрөг мэдээлээгүй.	1	55,072.9						1	55,072.9
Дүн	1	55,072.9						1	55,072.9
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил									
Засгийн газрын хувь оролцоог санхүүгийн тайланд тусгаагүй	1	224,688.4						1	224,688.4
ААНОАТ тайлан тушаагаагүй хоцорсон төлөвтэй байна.	1							1	
Дүн	2	224,688.4						2	224,688.4
Нийт дүн	3	279,761.3						3	279,761.3